



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,

Цахим шуудан: info@cabinet.gov.mn,

Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.03.21 № ХТ / 782

танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 121, 2015 оны 478 дугаар тогтоолын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгатай холбогдуулан дараах мэдээллийг Танд хүргүүлж байна:

1.Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.1, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 30 дугаар тогтоолын 1 дэх заалтын 3 дахь дэд заалт болон Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 88 дугаар тогтоолыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.5-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх асуудлаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй хэлэлцээ хийх чиг үүргийг хариуцах Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийг томилоод байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 34 дүгээр захирамжаар Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.5-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх талаар саналын төсөл боловсруулах, энэ асуудлаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга ахлан ажиллаж байна.

2.“Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” Улсын Их Хурлын 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 27 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байршилтай Тавантолгойн чулуун нүүрсний орд (Тавантолгой ХК, Энержи ресурс ХХК, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн

700255006141

хэмжээнд нөөц тооцсон талбайг хамааруулна)-ыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод тооцон, мөн тогтоолын 4 дэх заалтаар “Стратегийн ач холбогдол бүхий...Таван толгой...ашигт малтмалын ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээ, түүнийг хэрхэн эзэмших талаархи саналыг эхний ээлжинд боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”-ийг Засгийн газарт үүрэг болгосон.

Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр геологийн хайгуулын ажил хийж, нөөцийг тогтоосон Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах тусгай зөвшөөрлийг төрийн мэдэлд авах асуудлаар яриа хэлэлцээр хийж, үр дүнг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх шийдвэрийн төсөл, танилцуулгыг Засгийн газарт оруулж хэлэлцүүлэх чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2007 оны 114 дүгээр захирамжаар байгуулсан байна.

Ажлын хэсгээс Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанд танилцуулга хийсний дагуу Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр “Тавантолгойн орд газрын хайгуулын тусгай зөвшөөрлийг буцаан авах талаар “Энержи ресурс” ХХК-тай байгуулах гэрээнд гарын үсэх зурах”-ыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүүд даалгасан.

Үүний дагуу Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж, тухайн үеийн Үйлдвэр, худалдааны сайд, “Энержи ресурс” ХХК-ийг төлөөлж, тус компанийн Гүйцэтгэх захирал нар 2008 оны 03 дугаар сарын 21-ний өдөр “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай гэрээ” гэх баримт бичигт гарын үсэг зурж, тус компанийн эзэмшиж байсан Тавантолгойн ордод хамаарах ашигт малтмалын ашиглах 5 зөвшөөрлийг буцаан авч, харин Ухаа худаг ордыг ашиглах тусгай зөвшөөрлийг хэвээр үлдээсэн байна.

Энэ талаар Улсын Их Хурал, Засгийн газрын өмнө гаргасан шийдвэрт дүн шинжилгээ хийж, холбогдох санал, дүгнэлт боловсруулж танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 32 дугаар захирамжаар байгуулан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл ахлан ажиллаж байна.

3.“Концессын гэрээ цуцалсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 478 дугаар тогтоолыг Концессын тухай хууль /2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн хүчингүй болсон/-ийн 24.4 дэх хэсэгт “Концессын гэрээг цуцлахад талуудад олгох нөхөх олговрыг хэрхэн тооцохыг гэрээнд заах ба ингэхдээ концессын гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын зохих үнэ цэнэ, гарсан зардал, тухайн талд учирсан хохирол, үүний дотор шаардлагатай тохиолдолд олох боломжтой байсан ашгийг оруулна.” гэж заасныг үндэслэн баталсан байна.

Уг тогтоолын 1.2-т заасны дагуу концесс эзэмшиж байсан этгээдэд төлөх төлбөрийг Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 121 дүгээр тогтоол гарсан өдрийн Монголбанкны ам.долларын албан ханшаар тооцсон дүн болох 60,335,716.4 ам.доллар байхаар тогтоож, уг төлбөрийг тус тогтоолын 4-т


заасан бондын хүүгийн хамт төлөх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд болон Зам, тээврийн сайд нарт даалгасан.

Энэ хүрээнд Сангийн сайдын 2016 оны 22 болон 41 дүгээр тушаалын дагуу 59,775,945.27 ам доллар буюу 119,514,231,694.48 төгрөг бүхий 15.2 хувийн хүүтэй векселийг 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр бичсэн байна.

Мөн Засгийн газрын 2015 оны 478 дугаар тогтоолын 4 дэх хэсэг болон Засгийн газрын 2016 оны 284 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн 2013 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл хуримтлагдсан хүүгийн төлбөр болох 14,279,601.59 ам.долларын санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор "Энержи Ресурс" ХХК-д нийт 31,894,346,927.36 төгрөгийн вексель бичиж төлсөн байна.

Хавсралт 1 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Дон-зэнгийн гудамж т/г,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим агуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Н.УЧРАЛ ТАНАА**

2025.03.10 № 01/1590
танай _____ ний № ХЭТ/371

Хариу хүргүүлэх тухай

"Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай" Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоол болон Засгийн газрын 2012 оны 121, 2015 оны 478 дугаар тогтоолын хэрэгжилтийн асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижирийн асуулгатай танилцаад Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 9-д заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хариулт бэлтгэн хүргүүлж байна.

Засгийн газрын 2015 оны 478 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар

"Концессын гэрээ цуцалсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2015 оны 478 дугаар тогтоолын 1.2-т заасны дагуу концесс эзэмшиж байсан этгээдэд төлөх төлбөрийг Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоол гарсан өдрийн Монголбанкны ам.долларын албан ханшаар тооцсон дүн болох 60,335,716.4 ам.доллар байхаар тогтоож, уг төлбөрийг тус тогтоолын 4-т заасан бондын хүүгийн хамт төлөх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд болон Зам, тээврийн сайд нарт даалгасан.

Энэ хүрээнд Сангийн сайдын 2016 оны 22 болон 141 дүгээр тушаалын дагуу 59,775,945.27 ам.доллар буюу 119,514,231,694.48 төгрөг бүхий 15.2 хувийн хүүтэй векселийг 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр бичсэн байна.

Мөн Засгийн газрын 2015 оны 478 дугаар тогтоолын 4 дэх хэсэг болон Засгийн газрын 2016 оны 284 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн 2013 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл хуримтлагдсан хүүгийн төлбөр болох 14,279,601.59 ам.долларын санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор "Энержи Ресурс" ХХК-д нийт 31,894,346,927.36 төгрөгийн вексель бичиж төлсөн байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9762000596